



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 15 сарын 19 өдөр

Дугаар А/45

Хажуу шинэ ус

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог хангах орон  
тооны бус дэд зөвлөл байгуулах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хамгаалах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамгаалах тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог хангах орон тооны бус дэд зөвлөлийг хавсралтаар баталсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний соёл, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжүүлэх, эрх чөлөөг хүндэтгэх талаар олон талт үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг нарийн бичгийн дарга /нийгмийн бодлогын мэргэжилтэн/-д үүрэг болгосугай

ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

2021 оны 05 дугаар сарын  
18 өдрийн 1/4 тоот захирамжийн  
хавсралт



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог хангах орон  
тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга  
Гишүүд

Засаг дарга

Сум дундын эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Сургуулийн өмнөх боловсролын эрхлэгч

Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал, хариуцсан мэргэжилтэн

Сургуулийн нийгмийн ажилтан

1-р багийн Засаг дарга

2-р багийн Засаг дарга

3-р багийн Засаг дарга

4-р багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Нийгмийн бодлогын мэргэжилтэн